



Завхан аймаг дахь
Төрийн аудитын газар



“АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ”



ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ОРХИГДСОН БАЙНА

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Х.Болдбаатар
Утас: 7046-3783, Цахим хаяг: boldbaatar@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Жалбаа
Утас: 89330330, Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn
Аудитор Д.Пүүжмаа
Утас: 99080797, Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn
Аудитор Л.Гансүлд
Утас: 88161818, Цахим хаяг: gansuldl@audit.gov.mn

Улиастай сум
2025 он

Аудитын харилцан хамаарал:

Төрийн өмчийн зүйлсийн тухай ойлголт, ангилал: Төрийн өмч нь төрийн нийтийн зориулалттай өмч, төрийн өөрийн өмчөөс бүрдэнэ. Эдгээр өмч нь Иргэний тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөнд хуваагдана.

Иргэний тухай хуулийн **84 дүгээр зүйл. Эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгө**

84.1.Аливаа этгээдийн эзэмшилд байгаа эд юмсыг эд хөрөнгө гэнэ.

84.2.Эд хөрөнгө нь үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө байна.

84.3.Газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмс үл хөдлөх эд хөрөнгөд хамаарна.

84.4.Энэ хуулийн 84.3-т зааснаас бусад эд юмс хөдлөх эд хөрөнгөд хамаарна.

84.5.Эзэмшигч этгээддээ ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлага, оюуны үнэт зүйл нь эдийн бус хөрөнгөд хамаарна.

Төрийн өмчийн зүйлсийн харилцааг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулиар зохицуулдаг.



Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 64 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллагын данс бүртгэлд 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 81,997.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 2,756.27 сая төгрөгийн бараа материал бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн нийт үлдэгдэл /сая.төг/

Он	Нийт үлдэгдэл	Үүнээс							
		Барилга, байгууламж	Тээврийн хэрэгсэл	Тоног төхөөрөмж	Тавилга, эд хогшил	Ном	Бусад үндсэн хөрөнгө	Программ хангамж	Бусад биет бус хөрөнгө
2020	46,840.27	24,023.78	5,212.10	9,383.32	1,679.59	24.65	4,571.29	113.66	1,831.87
2021	47,386.82	24,120.99	5,478.66	9,415.62	1,667.52	24.85	4,734.39	114.11	1,830.67
2022	57,443.02	30,526.24	6,247.11	10,250.67	1,779.82	23.67	5,774.97	118.67	2,721.88
2023	66,629.36	33,557.88	7,995.88	12,307.20	1,795.92	28.66	7,771.63	175.04	2,997.15
2024	81,997.88	37,640.36	12,670.98	15,325.21	2,233.41	30.36	9,783.58	179.28	4,134.70
Зөрүү	35,157.61	13,616.58	7,458.88	5,941.89	553.82	5.71	5,212.29	65.62	2,302.83
Өсөлт %	42.88	36.18	58.87	38.77	24.79	18.81	53.28	36.60	55.69



Үндсэн хөрөнгийн 2024 оны үлдэгдлийг 2020 онтой харьцуулахад 5 жилийн хугацаанд 35,157.61 сая төгрөгөөр буюу 42.9 орчим хувийн өсөлттэй байна.

Бараа материалын үлдэгдэл сая.төг

Он	Нийт үлдэгдэл	Үүнээс									
		Тусгай зориулалтын материал	Эм боох материал	Бэлэн бүтээгдэхүүн	Бичиг хэргийн материал	Аж ахуйн материал	Сэлбэг хэрэгсэл	Түлш, шатлах тослох материал	Барилгын засварын материал	Бусад хангамжийн материал	Мал, амьтад
2020	1,095.95	37.25			48.21	501.08		39.93	11.76	266.36	167.36
2021	1,149.10	46.96	2.00	0.11	53.39	547.89	39.60	20.81	22.11	304.39	111.85
2022	1,612.11	95.33	2.00	0.92	55.54	798.60	27.66	22.95	23.70	486.68	98.72
2023	2,055.10	194.14	2.00	0.89	62.62	899.85	43.73	86.63	30.13	638.78	93.34
2024	2,756.27	142.00	2.43	0.89	69.13	1,178.97	57.94	77.53	50.01	1,100.85	76.44

Аудитын зорилго ба хамрах хүрээ:

Аудитын зорилго нь Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын байдалд аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын гол асуудал:

- Орон нутгийн өмчид хөрөнгө бэлтгэхдээ хэрэгцээ шаардлагад үндэслэсэн эсэх;
- Орон нутгийн өмчийг зориулалтын дагуу ашиглаж, хууль журамд нийцүүлэн зарцуулсан эсэх;
- Орон нутгийн өмчийн ашиглалтад, хамгаалалтад тавих хяналт хангалттай эсэх;

Аудитад хамрагдсан байгууллага:

Аудитад аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 25, Засаг даргын Тамгын газрын 25, засаг даргын дэргэдэх алба, газрын 9, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 5, нийт 64 байгууллага, тэдгээрийн дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгө, бараа материалын 2020-2024 он хүртэлх хугацааны хөдөлгөөн, ашиглалт, хамгаалалт, үлдэгдэл зэргийг хамруулан аудитыг хийж гүйцэтгэсэн.

Аудитын хязгаарлалт:

- ❖ Аудитад хамрагдах байгууллагуудын эд хөрөнгө хариуцагч алба хаагчид ээлжийн амралттай байх.

Аудитын гол үр дүн:**ЗОРИЛТ 1. ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨМЧ ХӨРӨНГИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН ТАЛААРХ СУДАЛГАА ХИЙГЭЭГҮЙГЭЭС ИЛҮҮДЭЛ ХӨРӨНГӨ БИЙ БОЛСОН БАЙНА.**

Аудитаар эхний асуудлын хүрээнд орон нутгийн өмчид хөрөнгө олж бэлтгэх үйл явц, түүнийг данс бүртгэлд тусгасан байдал, орон нутгийн өмчийн эрх зүйн орчинд дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулах ажлыг гүйцэтгэсэн.

Орон нутгийн өмчид олж бэлтгэсэн хөрөнгүүд нь дараах эх үүсвэрээс бүрдсэн байна.



Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын өмч хөрөнгө 2020-2024 онуудад нийт 44,979.63 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Орон нутгийн өмч хөрөнгө нэмэгдсэнээр гарч буй эрсдэл, зөрчил

ЗӨРЧИЛ

Орон нутгийн өмчид хөрөнгө бэлтгэхэд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн шийдвэр гаргаагүй, нэн ялангуяа тээврийн хэрэгсэл худалдан авахтай холбоотой асуудлыг аймгийн ИТХ-аар хэлэлцээгүй нь учир дутагдалтай байна.

Орон нутгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүд чанаргүй, ашиглалтад хүлээн авсан мөчөөс одоог хүртэл ашиглалтгүй, эвдэрч гэмтсэн, төсөв захирагч нар барилгын ашиглалтыг сайжруулах, засаж сэргээх ажлыг хийгээгүй, тэдгээртэй адил хөрөнгийг дахин барьж, үхмэл хөрөнгүүдийг бий болгосон.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар мотоцикл нийлүүлэхдээ төсөвт байгууллагуудын хөрөнгийн үлдэгдэлд дүн шинжилгээ хийж, хэрэгцээ шаардлагыг бодитой тодорхойлоогүйгээс хөрөнгийн давхардал бий болсон.

ИРГЭД

Байгууллагуудын дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн гэрчилгээг тухайн байгууллагуудын нэр дээр шилжүүлдэггүй, худалдан авсан хувь иргэн, хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй зөрчлүүд нийтлэг байна

Алба хаагчдад шинээр худалдан авсан хөрөнгийг өгөхдөө өмнө нь ашиглаж байсан хөрөнгийн ашиглалтын байдлыг үнэлж, дүгнэлт гаргалгүй нэмж өгдөг.

Байгууллагын дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй.

- Төсвийн хөрөнгө үр ашиггүй, үрэлгэн зарцуулагдах,
- Хөрөнгийн эх үүсвэр давхардаж, орон нутгийн өмчид хөрөнгийн илүүдэл үүсэж, ашиглалтгүй хөрөнгө бий болох,
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт суларч, хөрөнгө дутагдах, тоногдох, эзэнгүйдэх, эвдэрч гэмтэх,
- Эрх бүхий байгууллага, иргэд олон нийтээс тавих хяналт алдагдах.

ЭРСДЭЛ

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад илүүдэлтэй байгаа хөрөнгийг хэрэгцээтэй газарт шилжүүлэх, үнэ цэнээ алдаж, эвдэрч гэмтэхээс өмнө худалдан борлуулах, орон нутгийн өмчит хөрөнгө бэлтгэхдээ аймгийн ИТХ-аар хэлэлцэж, тухайн байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцүүлж байх, орон нутгийн өмч хөрөнгийн харилцааг зохицуулж буй журмыг шинэчлэн боловсруулах зөвлөмжүүдийг хүргүүлсэн.

ЗОРИЛТ 2. ХӨРӨНГИЙГ БОГИНО ХУГАЦААНД ЭЛЭГДҮҮЛЭН, ДАНС БҮРТГЭЛЭЭС ХАСДАГ НИЙТЛЭГ ЗӨРЧИЛ БИЙ БОЛСОН БАЙНА.

Аудитын 2 дугаар асуудлын хүрээнд:

- ❖ Хөрөнгийн ашиглалтын хугацааг бодитой тодорхойлж, дахин үнэлж, хугацааг сунгасан байдал,
- ❖ Хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хууль журамд заасан үндэслэлээр данс бүртгэлээс хасаж байгаа эсэх,
- ❖ Өмч хөрөнгийг бусдад ашиглуулсны /түрээсийн/ төлбөр болон нээлттэй дуудлага худалдаагаар борлуулсны орлогыг төсөвт төвлөрүүлсэн байдал зэргийг хамруулан дүгнэлт өгсөн.



Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тогтоохдоо төсөвт байгууллагууд Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан аргачлалыг баримталж байна. Уг аргачлалд сайн буюу шинэ, дундаж буюу цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэхэд баримтлах хугацааг тогтоож өгчээ.



Барилга байгууламжийн хувьд барилгын хийц, материалаас, Тээврийн хэрэгслийн /машин, механизм/ хувьд зориулалтаас, хамааран хугацааг тодорхойлохоор заасан байна. 2020-2024 онд данс бүртгэл тусгасан хөрөнгүүдийн ашиглалтын хугацаанд ажиглалт хийхэд 80 орчим хувь нь элэгдлийн хугацааг Сангийн сайдын тушаалаар баталсан аргачлалтай уялдуулаагүй, бага жилээр тогтоосон

Мотоциклийн элэгдэл тооцох хугацаа нь тодорхой бус бөгөөд байгууллагууд 3-10 жилээр, өөр өөр тогтоосон байна



Байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хэрэглэгддэг компьютер, принтерийн элэгдэл тооцох хугацаанд ажиглалт хийхэд 3-5 жилээр элэгдэх тооцох хугацааг тогтоосон нь аргачлалд заасан хугацаанаас 4-5 жилээр, тавилга, эд хогшлын элэгдэл тооцох дундаж хугацаа 7 жил байгаа нь аргачлалд заасан хугацаанаас 5 жилээр бага байна бага байна.

Эрх бүхий байгууллагуудаас гаргасан өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрүүдийн үр дүнд шинжилгээ хийхэд бусдад давуу байдал олгох эрсдэлийг дагуулсан байна гэж аудитаар үзсэн: Үүнд:

Үндсэн хөрөнгийг богино хугацаанд элэгдүүлэн данс бүртгэлээс хассан.

Ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар борлуулах, сэлбэгээр худалдах зэрэг шаталсан арга хэмжээ авалгүй акталсан.

Байгууллагын дансанд бүртгэлтэй хөрөнгө дутагдсан, хулгайд алдагдсан, тоногдсон байхад буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллалгвй. актлах шийдвэр гаргасан.

Тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг нүд үзэж, бодит байдлыг үнэлэлгүй акталж, данснаас хасхаар шийдвэрлэсэн.

Нээлттэй дуудлага худалдаагаар худалдах хөрөнгө зарагдаагүй байхад данс бүртгэлээс хассан, балансаас шилжүүлсэн хөрөнгө байгууллагуудын дүнд бүртгэлгүй орхигдсон.

Тавилга, эд хогшлоос бусад төрлийн хөрөнгийг Аймгийн ИТХ-ын шийдвэрт үндэслэн данс бүртгэлээс хасахаар журамд заасан байхад сумын ИТХ-ын шийдвэрээр бусад үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан.


Хөрөнгийн шинжтэй зүйлийг бараа материалын дансанд бүртгэж, эрх бүхий байгууллагын шийдвэргүй данс бүртгэлээс хассан.

Аудитын хүрээнд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд дүгнэлт өгөх зорилгоор төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 64 байгууллагын үндсэн хөрөнгийг 2024 оны жилийн эцсийн үлдэгдэлтэй тулган биет тооллогыг хийхэд дараах нөхцөл байдалтай байна.



Улс төрийн алба хаагчдын эзэмшиж буй хөрөнгийг тухай бүр ажил үүрэг солигдох, ажлаас чөлөөлөгдөх үед нь буцаан авч хүлээлцдэггүй, үүний улмаас хөрөнгө дутагдах, хаана байгаа нь тодорхой бус нөхцөл байдлууд үүссэн. Аудитаар 133.1 сая төгрөгийн 82 мотоцикл бодитоор байгаа эсэх нь тодорхой бус, тооллогод хамрагдаагүй.

Иргэн хуулийн этгээдэд орон нутгийн өмч, хөрөнгийг ашиглуулахдаа холбогдох гэрээнүүдийг /түрээс, ашиглалт, хариуцлага/ хийгээгүй нь тухайн хөрөнгийг хэнд хэзээ өгснийг тодорхойлох боломжгүй, хөрөнгө дутагдах эрсдэлүүдийг бий болгосон.



Төрийн байгууллагуудын тооллогын комисс хөрөнгө, бараа материалыг нүд үзэн тоолдоггүй, нэр төдий хийдэг нь хөрөнгө дутагдах, тухайн хөрөнгө хэзээнээс алга болсныг тодорхойлох боломжгүй байдлыг бий болгосон байна.

Аудитаар дээрх нөхцөл байдалтай холбоотой 578.43 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан зөрчил илэрсэнд дүн шинжилгээ хийж холбогдох эрх бүхий алба

хаагчдад зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн акт тогтоох шийдвэрүүдийг хүргүүлсэн.

Төрийн өмч хөрөнгийг бусдад ашиглуулсны/түрээсийн/ төлбөр, нээлттэй дуудлага худалдаагаар борлуулсны орлогыг төсөвт төвлөрүүлсэн байдалд хяналтыг хэрэгжүүлэхэд дараах байдалтай байна.

Түрээсийн орлого: Орон нутгийн өмчийн дансанд түрээсийн орлогоор 71.69 сая төгрөг төвлөрүүлсний 55.02 сая төгрөг буюу 76.75 хувь нь төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудаас төвлөрүүлсэн байна.

ОРОН НУТГИЙН
ТӨСӨВ

Түрээсийн орлого нь ихэвчлэн төрийн байгууллагуудын конторын өрөө, тасалгааг бусдад түрээслүүлсний орлогоос бүрджээ. Түрээсийн орлогоор 2024 онд нийт 91.2 сая төгрөгийн орлого, үүнээс орон нутгийн төсөвт 28.9 сая төгрөг /30%/ төвлөрүүлэхээс 21.69 сая төгрөг төвлөрүүлжээ.



Төвлөрүүлээгүй үлдэгдлийг судлан үзэхэд гэрээний үүргээ биелүүлэн ажиллаагүй түрээслэгчийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Орон нутгийн өмчийн түрээсийн 2024 онд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэхэд:

- ✓ Гэрээг санхүүгийн жилээр байгуулаагүй,
- ✓ Гэрээний дагуу түрээсийн орлого бүрэн төвлөрүүлээгүй,
- ✓ Түрээслэгч байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулсан баримт үйлдээгүй,
- ✓ Архивын нэгж үүсгээгүй нөхцөл байдалтай байна.

Дуудлага худалдааны орлого: Аудитын хамрах хугацаанд эрх бүхий байгууллагын 17 шийдвэрээр 67 нэр бүхий 1,520.97 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаа, сэлбэг хэрэгслээр худалдсанаас орон нутгийн төсөвт 454.05 сая төгрөг төвлөрүүлэхээр байна. Үүнээс 39.86 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 тээврийн хэрэгслийг балансаас шилжүүлсэн, 120.44 сая төгрөгийн 12 нэр бүхий хөрөнгө зарагдаагүй байна.

Дуудлага худалдааны орлогыг хөрөнгийн нэр, төрөл бүрээр дансны хуулгаар тулгалт хийхэд дараах нөхцөл байдалтай байна.



- Хөрөнгийн дуудлага худалдааны дэнчингийн мөнгийг дансанд тухай бүр тушаагаагүй,
- Худалдах, худалдан авах гэрээний дүнтэй дансаар орсон орлогыг тулган тооцоо бодоогүй,

- Дуудлага худалдаагаар зарагдсан хөрөнгийн төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй,
- Сэлбэг, хэрэгслээр худалдсан хөрөнгийн орлого болон хулгайд алдсан хөрөнгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлсний орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн зэрэг байна.

Цаашид аливаа шийдвэр гаргахдаа бодит нөхцөл байдлыг шударгаар үнэлж, бусдад давуу байдал олгохгүй байх, төсөвт нөлөөлөх байдал, үр дагаврыг тооцоолж байх, өмч хөрөнгөтэй холбоотой орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлж байх талаар холбогдох эрх бүхий алба хаагчдад зөвлөмж, албан шаардлага хүргүүлсэн.

ЗОРИЛТ 3. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Аудитын 3 дугаар асуудлын хүрээнд аймаг сумдын ИТХ болон бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтан төрийн өмч хөрөнгөнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлсэн байдал, хийсэн ажлын үр дүн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд горим сорил хэрэгжүүлэн дүгнэлт өгсөн.

ИТХ нь тухайн төлөөлөн



аймаг, сумын өмчийн зүйлсийг хүн амаа өмчлөгч байна.

Аудитаар орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалттай холбоотой дараах нөхцөл байдлууд илэрсэн.

Эрх бүхий байгууллагаас гарсан өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрийн хэрэгжилтийг хангуулан ажиллаагүй, хяналт тавьдаггүй,

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь орон нутгийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах, түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах эрхээ хэрэгжүүлээгүй,

Засаг дарга нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуульд заасан эд хөрөнгийн тооллогыг жил бүр зохион байгуулж, ИТХ-д дүнг хэлэлцүүлэх эрхээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй,

Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөл нь хөрөнгийн ашиглалт хамгаалалтад хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх үндсэн үүргээ хэрэгжүүлээгүй,

Байгууллагын эд хариуцагч, нярав, нягтлан бодогч нар хөрөнгөө хаана байгааг мэдэхгүй, хэнд эзэмшүүлсэн нь тодорхой бус, дутагдсан, бодитоор байхгүй хөрөнгүүдийг байгаагаар тоолсон,

Төсөв захирагч нартай байгуулсан “төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г бодитой, бүрэн дүгнэж, гэрээний хэрэгжилт хангалтгүй алба хаагчдад хариуцлага тооцож, зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллаагүй,

Хөрөнгийн хадгалалт хангалтгүй, хөрөнгө хулгайд алдагдсан, тоногдсон, хаана, хэн эзэмшиж, ашиглаж байгаа нь тодорхой бус,

Тээврийн хэрэгслийг хэн дуртай нь унаж үргүй зардал гаргадаг /амралтын хугацаандаа төрийн машин ашигладаг, тээврийн хэрэгсэл ашиглах эрхгүй алба хаагчид тээврийн хэрэгсэл ашигладаг/,

Байгууллагуудын тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж ихсэж, тухайн хөрөнгүүдийг хадгалах агуулах, зоорины хүрэлцээ хангалтгүйгээс иргэн, айл өрхийн хашаанд байршуулсан, орон гэртээ аваачиж хадгалсан

Аудитаар нийт 8,773.54 сая төгрөгийн зөрчил илрүүлэн 7,976.26 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 779.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 17.48 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож холбогдох эрх бүхий байгууллага, алба хаагчдад хүргүүлсэн.

Аудитын тайлан, дүгнэлт, аудитаар илэрсэн зөрчил, өгсөн шийдвэртэй дэлгэрэнгүй танилцахыг хүсвэл www.audit.mn цахим хуудаснаас үзнэ үү.